



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/80/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayarj@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа.....	Error! Bookmark not defined.
4.2 Төлбөрийн акт.....	Error! Bookmark not defined.
4.3 Албан шаардлага	13
4.3 Зөвлөмж	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2022.02.24 № 12/103

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

005020484

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Төгрөгөөр/ Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	48,453,034.20	52,146,984.20
33	АВЛАГА	9,894,242.00	9,242.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	9,242.00	9,242.00
335	Бусад авлага	9,885,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	9,885,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	38,558,792.20	52,137,742.20
351	Түүхий эд материал	3,610,000.00	4,620,000.00
35110	Тусгай зориулалттай материал	3,000,000.00	3,000,000.00
35130	Эм боох материал	610,000.00	1,620,000.00
354	Хангамжийн материал	34,948,792.20	47,517,742.20
35410	Бичиг хэргийн материал	736,100.00	00.00
35420	Аж ахуйн материал	8,679,536.00	7,825,861.00
35440	Түлш, шатах тослох материал	237,100.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	25,296,056.20	39,691,881.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	785,585,756.94	810,805,028.52
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	785,585,756.94	810,805,028.52
392	Биет хөрөнгө	766,061,756.94	791,281,028.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	858,547,377.00	858,547,377.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-184,573,974.04	-215,648,753.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	166,176,879.91	234,480,879.91
39206	Хуримтлагдсан элэгдэл	-145,829,357.19	-152,996,244.23
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	88,577,079.80	95,787,235.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	-52,976,374.77	-61,550,472.33
39214	Бусад үндсэн хөрөнгө	46,741,537.12	46,741,537.12
39215	Хуримтлагдсан элэгдэл	-25,572,998.49	-29,572,998.45
39217	Ном	14,971,587.60	15,492,467.60
393	Биет бус хөрөнгө	19,524,000.00	19,524,000.00
39301	Програм хангамж	200,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-200,000.00	-200,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	19,524,000.00	19,524,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	834,038,791.14	862,952,012.72
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	834,038,791.14	862,952,012.72
51	Засгийн газрын хувь оролцоо	834,038,791.14	862,952,012.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	290,170,245.35	290,170,245.35
51101	Өмч: - төрийн	290,170,245.35	290,170,245.35
512	Хуримтлагдсан үр дүн	-15,230,551.43	13,682,670.15
51210	Өмнөх үеийн үр дүн	-15,230,551.43	-15,230,551.43
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	28,913,221.58
51300	Хөрөнгийн дахин үнэлээний зөрүү	559,099,097.22	559,099,097.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	834,038,791.14	862,952,012.72

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	760,154,107.00	656,394,424.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	123,686,107.00	35,657,360.30
120	Нийтлэг татварын бус орлого	123,686,107.00	35,657,360.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	123,686,107.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	123,386,107.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	31,461,035.30
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	00.00	4,196,325.00

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	636,468,000.00	620,737,064.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	523,914,400.00	525,782,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	523,914,400.00	525,782,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,780,500.00	18,384,798.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,918,400.00	5,472,580.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,862,100.00	12,912,218.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	84,773,100.00	76,569,466.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	84,773,100.00	76,569,466.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	672,991,019.41	627,481,202.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	672,991,019.41	627,481,202.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	593,528,838.41	578,354,154.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	386,039,502.00	375,959,021.00
210101	Үндсэн цалин	380,037,151.00	319,361,693.00
210102	Нэмэгдэл	00.00	31,922,803.00
210104	Урамшуулал	1,708,636.00	24,674,525.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,293,715.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,480,458.00	46,350,700.00
210201	Тэтгэврийн даатгал	33,223,436.00	33,563,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,840,359.00	3,190,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,072,285.00	2,542,500.00
210204	Ажигүйдлийн даатгал	741,712.00	631,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,602,666.00	6,422,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,584,922.00	76,261,966.00
210301	Гэрэл, пахилгаан	2,892,682.00	3,464,226.00
210302	Түлш, халаалт	67,692,240.00	72,648,340.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	149,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,164,333.00	8,631,761.00
210401	Бичиг хэрэг	590,000.00	1,734,700.00
210402	Тээвэр, шатахуун	3,633,710.00	3,766,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,606,973.00	835,861.00
210404	Ном, хэвлэл	55,950.00	72,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	636,000.00	405,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	438,500.00	1,817,700.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	203,200.00	00.00
2105	Нормативт зардал	13,523,860.00	8,894,450.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	853,700.00	1,803,700.00
210502	Хоол, хүнс	11,114,160.00	6,831,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,556,000.00	258,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,460,000.00	2,195,575.00
210604	Урсгал засвар	5,460,000.00	2,195,575.00
2107	Томилолт, зочны зардал	808,000.00	350,000.00
210702	Дотоод албан томилолт	808,000.00	350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,960,300.00	2,756,718.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,510,300.00	2,016,718.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,507,463.41	56,953,963.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,958,000.00	4,194,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	555,000.00	1,944,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	56,994,463.41	50,815,763.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,462,181.00	49,127,048.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,681,600.00	13,795,080.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,561,600.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,304,400.00	7,961,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,815,600.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	5,472,580.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	361,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,319,678.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,319,678.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,460,903.00	35,331,968.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,960,903.00	35,331,968.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	87,163,087.59	28,913,221.58
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	9,720,000.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	9,720,000.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-9,720,000.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	77,443,087.59	28,913,221.58

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
		/Төгрөгөөр/	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	636,768,000.00	620,737,064.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	300,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	300,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	300,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	636,468,000.00	620,737,064.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	523,914,400.00	525,782,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	523,914,400.00	525,782,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,780,500.00	18,384,798.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,918,400.00	5,472,580.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,862,100.00	12,912,218.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	84,773,100.00	76,569,466.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	84,773,100.00	76,569,466.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	631,283,706.00	586,048,064.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	631,283,706.00	586,048,064.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	551,769,925.00	536,957,126.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	386,720,818.00	375,995,131.00
210101	Үндсэн цалин	302,263,474.97	319,284,550.00
210102	Нэмэгдэл	38,287,984.81	32,036,056.00
210104	Урамшуулал	46,169,358.22	24,674,525.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,824,552.00	46,350,700.00
210201	Тэтгэврийн даатгал	33,362,098.00	33,563,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,083,707.00	3,190,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,995,403.00	2,542,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	769,544.00	631,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,613,800.00	6,422,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,584,922.00	75,569,466.00
210301	Гэрэл, цахилгаан	2,892,682.00	3,008,826.00
210302	Түлш, халаалт	67,692,240.00	72,411,240.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	149,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,573,912.00	10,155,861.00
210401	Бичиг хэрэг	1,161,600.00	993,600.00
210402	Тээвэр, шатахуун	3,633,710.00	3,665,660.00
210403	Шуудан, холбоо, ингэрнэтийн төлбөр	1,577,652.00	1,291,261.00
210404	Ном, хэвлэл	55,950.00	72,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	560,000.00	435,840.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,585,000.00	3,697,500.00
2105	Нормативт зардал	12,084,200.00	9,669,650.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,181,200.00	1,618,900.00
210502	Хоол, хүнс	9,697,000.00	6,831,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,206,000.00	1,218,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,864,500.00	2,195,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,496,000.00	00.00
210604	Урсгал засвар	5,368,500.00	2,195,600.00
2107	Томилолт, зочны зардал	766,000.00	350,000.00
210702	Дотоод албан томилолт	766,000.00	350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,908,700.00	8,728,218.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,458,700.00	7,988,218.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	240,000.00

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,442,321.00	7,942,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,283,000.00	5,993,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,159,321.00	1,949,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,513,781.00	49,090,938.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,733,200.00	13,758,970.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,304,400.00	7,961,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,815,600.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,613,200.00	5,472,580.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	324,990.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,319,678.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,319,678.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,460,903.00	35,331,968.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,960,903.00	35,331,968.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,484,294.00	34,689,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,484,294.00	34,689,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,484,294.00	34,689,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,484,294.00	34,689,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,484,294.00	34,689,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-5,484,294.00	-34,689,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	290,170,245.35	559,099,097.22	-15,230,551.43	834,038,791.14
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	290,170,245.35	559,099,097.22	-15,230,551.43	834,038,791.14
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	290,170,245.35	559,099,097.22	-15,230,551.43	834,038,791.14
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	28,913,221.58	28,913,221.58
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	290,170,245.35	559,099,097.22	13,682,670.15	862,952,012.72

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /					
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	605,338,200.00	567,020,298.00	38,317,902.00	93.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	605,338,200.00	567,020,298.00	38,317,902.00	93.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	587,077,800.00	558,733,908.00	28,343,892.00	95.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	393,475,700.00	375,995,131.00	17,480,569.00	95.6
210101	Үндсэн цалин	333,217,200.00	319,284,550.00	13,932,650.00	95.8
210102	Нэмэгдэл	34,992,900.00	32,036,056.00	2,956,844.00	91.6
210104	Урамшуулал	25,265,600.00	24,674,525.00	591,075.00	97.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,076,700.00	46,350,700.00	2,726,000.00	94.4
210201	Тэтгэврийн даатгал	36,143,900.00	33,563,900.00	2,580,000.00	92.9
210202	Тэтгэмжийн даатгал	3,233,200.00	3,190,200.00	43,000.00	98.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,586,500.00	2,542,500.00	44,000.00	98.3
210204	Ажилгүйдлийн даатгал	646,700.00	631,700.00	15,000.00	97.7
210205	Эрүүл мэндийн даатгал	6,466,400.00	6,422,400.00	44,000.00	99.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,555,400.00	75,569,466.00	2,985,934.00	96.2
210301	Гэрэл, цахилгаан	5,328,000.00	3,008,826.00	2,319,174.00	56.5
210302	Түлш, халаалт	72,527,400.00	72,411,240.00	116,160.00	99.8
210303	Цэвэр, бохир ус	700,000.00	149,400.00	550,600.00	21.3

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2104	Хангамж, бараа материалын зардал	11,521,900.00	10,455,861.00	1,066,039.00	90.7
210401	Бичиг хэрэг	993,600.00	993,600.00	00.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	3,700,000.00	3,665,660.00	34,340.00	99.1
210403	Шуудан, холбоо, ингэрнэгийн төлбөр	1,398,600.00	1,291,261.00	107,339.00	92.3
210404	Ном, хэвлэл	492,200.00	372,000.00	120,200.00	75.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,240,000.00	435,840.00	804,160.00	35.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,697,500.00	3,697,500.00	00.00	100.0
2105	Нормативт зардал	13,643,000.00	9,669,650.00	3,973,350.00	70.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,618,900.00	1,618,900.00	00.00	100.0
210502	Хоол, хүнс	10,805,200.00	6,831,850.00	3,973,350.00	63.2
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,218,900.00	1,218,900.00	00.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,495,600.00	31,495,600.00	00.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	29,300,000.00	29,300,000.00	00.00	100.0
210604	Урсгал засвар	2,195,600.00	2,195,600.00	00.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	355,600.00	350,000.00	5,600.00	98.4
210702	Дотоод албан томилолт	355,600.00	350,000.00	5,600.00	98.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,004,900.00	905,000.00	99,900.00	90.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	264,900.00	165,000.00	99,900.00	62.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	00.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00	00.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	794,900.00	794,250.00	6,500.00	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	5,993,500.00	6,500.00	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,949,000.00	1,949,000.00	00.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,260,400.00	8,286,390.00	9,974,010.00	45.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,260,400.00	8,286,390.00	9,974,010.00	45.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,899,300.00	7,961,400.00	9,937,900.00	44.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	361,100.00	324,990.00	36,110.00	90.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	605,338,200.00	567,020,298.00	38,317,902.00	93.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	525,782,800.00	490,450,832.00	35,331,968.00	93.3
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	525,782,800.00	490,450,832.00	35,331,968.00	93.3
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	79,555,400.00	76,569,466.00	2,985,934.00	96.2
132001	Орон нутгийн төсвөөс	79,555,400.00	76,569,466.00	2,985,934.00	96.2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	38.00	37.00	01.00	97.4
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	20.00	01.00	95.2
620003	Үйлчлэх ажилтан	16.00	16.00	00.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	38.00	37.00	01.00	97.4
650004	ССБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	21.00	20.00	01.00	95.2
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.00	11.00	00.00	100.0
650010	Гэрээт ажилтан	06.00	06.00	00.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	27,780,500.00	18,384,798.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	27,780,500.00	18,384,798.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,403,300.00	12,912,218.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		12,912,218.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		12,912,218.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,403,300.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,403,300.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,377,200.00	5,472,580.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,377,200.00	5,472,580.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,815,600.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,561,600.00	5,472,580.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	27,780,500.00	18,384,798.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,780,500.00	18,384,798.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,377,200.00	5,472,580.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,403,300.00	12,912,218.00
	Мөнгө, түүнгүй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнгүй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 1/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд тус байгууллагын төсвийн зарцуулалтад 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Б.Ууганбаяр, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Оюунгэрэл нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сурагч нэг бүрийг ёс зүйтэй, унших, бичих, ярих чадвараа хөгжүүлсэн, бие даасан, бүтээлч, эрүүл чийрэг иргэн болгон төлөвшүүлнэ.
- Боловсролын хөгжлийн чиг хандлага, нийгмийн болон хувь хүний хэрэгцээ шаардлагыг хангасан, сурах арга барил эзэмшсэн сайн сурагчийг төлөвшүүлсэн сургалтын байгууллага болно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 673,249.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,098.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,574.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 6,588.5 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28,913.2 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	48,453.0	52,147.0	3,694.0
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	9,894.2	9.2	(9,885.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	38,558.8	52,137.7	13,579.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	785,585.8	810,805.0	25,219.3
Үндсэн хөрөнгө	1,194,738.5	1,270,773.5	76,035.0
Хуримтлагдсан элэгдэл	(409,152.7)	(459,968.5)	(50,815.8)
Нийт хөрөнгө	834,038.8	862,952.0	28,913.2
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	834,038.8	862,952.0	28,913.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	834,038.8	862,952.0	28,913.2

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 9,885.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны 9,885.0 мянган төгрөгийн ухаалаг самбарын авлагыг тайлант онд барагдуулсан бол

тайлант ажиллагсадтай холбоотой хувь хүний орлогын албан татварын 9.2 мянган төгрөгийн авлага барагдаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 52,137.7 мянган төгрөг болж 13,579.0 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал дансны үлдэгдэл 1,010.0 мянга, бусад хангамжийн материал дансны үлдэгдэл 14,395.8 мянган төгрөгөөр тус тус өмнөх оноос нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,270,773.5 мянган төгрөг болж өмнөх оноос 76,035.0 мянган төгрөгөөр өссөн нь 34,689.0 мянган төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, үнэ төлбөргүй 31,461.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, өмнөх оны авлагаар бүртгэсэн 9,885.0 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 862,952.0 мянган төгрөг болж 28,913.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн 28,913.2 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд төсвийн нийт зарлагыг 759,021.1 мянга, санхүүжүүлэх эх үүсвэрийг 759,021.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 203,249.7 мянган төгрөгөөр бууруулж 555,771.4 мянган төгрөгөөр анх батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг 605,338.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр улсын төсвөөс 525,782.8 мянга, орон нутгийн төсвөөс 76,569.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 567,020.3 мянган төгрөгийг зарцуулж 35,332.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 567,020.3 мянган төгрөг буюу 93.7 хувьтай байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 20,206.6 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,985.9 мянга, хангамж бараа материалын зардлыг 1,066.0 мянга, нормативд зардлыг 3,973.3 мянга, үдийн цайны зардлыг 9,937.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд нийт 54 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 91.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 627,481.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 45,509.8 мянган төгрөгөөр буюу 6.8 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, дотоод албан томилолтын зардал, эд хогшил худалдан авах зардал өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 827,643.9 мянган төгрөгийн 151 мэдээлэл мэдээлэхээс 4-р улирлын төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг мэдээлээгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна.Үүнд:

- 2021 оны төсвийг 555,771.4 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 49,566.8 мянган төгрөг нэмж 525,782.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 79,555.4 мянган

төгрөгийн мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 567,020.3 мянган төгрөг зарцуулсан байгаа нь батлагдсан төсөвт 6.3 хувийн хэмнэлт гаргасан. Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс бусад урсгал зардлын төсвийг 188,803.5 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 26,017.7 мянган төгрөг хасаж 162,785.8 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 144,674.5 мянган төгрөг зарцуулсан байгаа нь анх батлагдсан төсөвт 23.4 хувийн хэмнэлт гаргасан.

- Бичиг хэргийн зардлыг 993.6 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 993.6 мянган төгрөг зарцуулсан байна.

- Байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 102,473.1 мянган төгрөгөөр, тодотголоор 78,555.4 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 75,569.5 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 26,903.6 мянган төгрөг буюу 26.3 хувь хэмнэсэн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 15,333.3 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, 1,665.2 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 569.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 3,213.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 9,885.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,939.9 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс 104.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлээгүй мэдээллийг нөхөн мэдээлэх 1 албан шаардлага өгч, алдаа, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 2,835.7 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлээ.

4.1 Төлбөрийн акт

1. Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 2021 оны 03 дугаар сард нэг хүүхэд өдрийн зардлыг 3626 төгрөгөөр тооцож нийт 104.2 мянган төгрөгийн хүнсний материал илүү зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах,” гэсэн заалт, Засгийн газрын 2019 оны “Хоолны зардлын норматив тогтоох тухай” 450 дугаар тогтоолын 2 дахь “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг 3475 (гурван мянга дөрвөн зуун далан таван) төгрөгөөр тогтоосугай” гэснийг тус тус зөрчсөн зөрчсөн санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар төлбөрийн акт тогтоож төлүүлсэн.

4.2 Албан шаардлага

Тус байгууллага нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2021 онд нийт 827,643.9 мянган төгрөгийн 151 мэдээлэл мэдээлэхээс 4-р улирлын төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулж, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

4.2 Зөвлөмж

1. Түлш шатахууны 4 сард зарцуулсан 237.1 мянган төгрөгийн материалыг нягтлан бодох бүртгэлд зарлагдаагүй үлдэгдлээр тайлагнасан, хагас жилийн эд хөрөнгийн тооллогоор тоологдсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1 дэх “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах” гэсэн заалтуудыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эд хөрөнгийн бүртгэлийг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв хөтөлж байх, мөн эд хөрөнгийн тооллогыг хийхдээ хөрөнгө тус бүрийг нэг бүрчлэн нүд үзэн тоолж, чанартай хийж түүнд тавих хяналтыг сайжруулах зөвлөмж өгөв.

2. Цалингийн зардлын гүйлгээг санхүүгийн программд тухай бүр үнэн зөв хөтлөөгүй, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг цалингийн сангаас шилжүүлсэн зэргээр цалингийн зардлыг 2127.2 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн зөрчилд завсрын аудитаар зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн ч зөвлөмжийг хэрэгжүүлээгүй цалингийн зардлыг 2598.6 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтуудыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтөлж бүртгэлийг сайжруулах, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нягтлан бодогчид хариуцлага тооцох зөвлөмж өгөв.

3. Байгууллагын 2021 оны төсвийг 555,771.4 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 49,566.8 мянган төгрөг нэмж 525,782.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 79,555.4 мянган төгрөгийн мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 567,020.3 мянган төгрөг зарцуулсан байгаа нь батлагдсан төсөвт 6.3 хувийн хэмнэлт гаргасан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар өгсөн зөвлөмжийн бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамт 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургууль	5	2939.9			1	104.2	1	-	3	2835.7

_____оОо_____